



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/302

Хэрлэн сум

**“Нэгдүгээрт хүүхэд” уриатай  
нөлөөллийн аян зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.9, Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн 2024 оны төлөвлөгөөний 4 дэх арга хэмжээг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан “Нэгдүгээрт хүүхэд” уриатай нөлөөллийн аян зохион байгуулах зардалд 3,924,000 (гурван сая есөн зуун хорин дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ